



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар A/595.

Ховд

┌ Улсын комисс байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Алтай сумын Барлаг багийн бетонон доторлогоотой суваг шуудуудын ажлыг хүлээн авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Н.Ганзориг –Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Жамбалдорж-Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын мэргэжилтэн

Д.Баатарсүрэн –Алтай сумын Засаг даргын Тамгын газрын  
дарга

Р.Тогтохбаяр –Хүнс, хөдөө аж ахуйн газрын агрономич

М.Эрдэнэсүрэн –Барлаг багийн Засаг дарга

Б.Очирбат –“Бат Дайчин” ХХК-ний захирал

Нарийн бичгийн  
дарга:


Ц.Пүрэвсүрэн – Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2 Бетонон доторлогоотой суваг шуудууны ажилтай холбогдон гарах зардлыг тухайн төслийн техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын

газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

3.Бетонон доторлогоотой суваг шуудууны ажлыг төсвийн дагуу шалгаж, норм нормативыг баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг улсын комиссын дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН